



БУЛГАН АЙМАГ
МОГОД СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 01/16

Эрхт

Тэргүүлэх чиглэл, зээлийн хүү, зээлийн дээд
хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 134 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.6 –ийн 1 дэх заалт, 3.1-ийн 3 дах заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сум хөгжүүлэх сангаас иргэн ААН-д олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг 3 хувь, нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг 15.0 сая төгрөг байхаар тогтоосугай.
2. Сум хөгжүүлэх сангаас зээл олгохдоо барилга байгууламж, малын хашаа барих, түлш бэлтгэх, түлээний зах, мал нядалгааны газар, үхэр тахианы фермер байгуулах, мал аж ахуйн түүхий эд боловсруулах, малын угшил чанарыг сайжруулах, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалах, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар зэрэг нэн шаардлагатай ажил үйлчилгээнд тэргүүн ээлжинд сонгон шалгаруулж олгох нь зүйтэй гэж үзсүгэй.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2013 оны 1 дүгээр сарын 9-ны өдрийн 01/07 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н ХАЛТАР